



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 17 өдөр

Дугаар А/265

Булган сум

Бэлчээр хамгаалах арга хэмжээг зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Ургамал хамгааллын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1, 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалт, Хүнс, Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны А/143 дугаар "Үлийн цагаан оготной тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлэх хуваарь батлах тухай" тушаал, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIV дүгээр хуралдааны 01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Бэлчээрийн ургамалд хөнөөл учруулж буй мэрэгч амьтантай энгийн механик, биологийн аргаар тэмцэх арга хэмжээг Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хаврын улиралд Сайхан, Рашаант, Дашинчилэн, Баяннуур, Гурванбулаг, Хангал сумдын бэлчээрийн 40.0 мянган га талбайд энэ оны 04 дүгээр сарын 20-ноос 05 дугаар сарын 20-ныг хүртэл, Улсын төсвийн хөрөнгөөр намрын улиралд Сайхан, Рашаант, Дашинчилэн, Баяннуур, Гурванбулаг сумдын бэлчээрийн 30.0 мянган га талбайд энэ оны 10 дугаар сарын 15-наас 11 дүгээр сарын 15-ныг хүртэлх хугацаанд тус тус зохион байгуулсугай.

2.Бэлчээрийн хөнөөлт мэрэгчидтэй тэмцэх ажлын Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар зохион байгуулах арга хэмжээний хуваарийг 1 дүгээр, Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар зохион байгуулах арга хэмжээний хуваарийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Уг арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг сайтар хангаж, ажиллах хүн, хүч, техник хэрэгсэл дайчлах, ажилгүй иргэд, малчдыг өргөнөөр оролцуулж, оновчтой зохион байгуулахыг холбогдох сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4.Дээрх арга хэмжээг хэрэгжүүлэх сумын Засаг дарга нартай гэрээ байгуулж, хугацаанд нь үр дүнтэй зохион байгуулах, мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангаж, хянал тавьж ажиллахыг Хүнс, Хөдөө аж ахуйн газар (Ч.Амгалан)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

БАРИУН-ЭРДЭНЭ



Булган аймгийн Засаг дарга 2023 өдөр бүр Дог/2023/Захирамж

6323010248

Аймгийн Засаг даргын 2023 оны
04 дүгээр сарын 17-ны өдрийн 1/265 дугаар
захирамжийн 1 дүгээр хавсралт

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР БЭЛЧЭЭРИЙН ХӨНӨӨЛТ
ҮЛИЙН ЦАГААН ОГОТНОТОЙ ТЭМЦЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХУВААРЬ

Д/д	Сумын нэр	Талбайн хэмжээ /га/	Төсөв	Тэмцэх арга
1	2	3	4	5
1	Баяннуур	7,000	11,200,000	Энгийн механик арга
2	Дашинчилэн	7,000	11,200,000	
3	Гурванбулаг	8,000	12,800,000	
4	Рашаант	10,000	16,000,000	
5	Сайхан	6,000	9,600,000	
6	Хангал	2,000	3,200,000	
	Нийт дүн	40,000	64,000,000	

Аймгийн Засаг даргын 2023 оны
ОН дүгээр сарын 11-ны өдрийн А/26 дугаар
захирамжийн 2 дугаар хавсралт



УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР БЭЛЧЭЭРИЙН ХӨНӨӨЛТ
МЭРЭГЧ АМЬТАНТАЙ ТЭМЦЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХУВААРЬ

Д/д	Сумын нэр	Талбайн хэмжээ /га/	Тэмцэх арга
1	2	3	4
1	Баяннуур	5 000	Энгийн механик, биологийн арга
2	Дашинчилэн	5 000	
3	Гурванбулаг	10 000	
4	Рашаант	5 000	
5	Сайхан	5 000	
	Нийт дүн	30 000	